СТОУС ТБ1, ТБ2 СТАНДАРТУУДЫГ МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДАЛ БА ЗАМЫН ЗУРГИЙН ШИНЖИЛГЭЭ

А.Наранцэцэг[1a]
[1] Мандах их сургууль, Ph.D. дэд профессор
[a] narantsetseg@mandakh.edu.mn

Өгүүлэл хүлээн авсан огноо: 20/05/2026
Өгүүлэл хэвлэсэн огноо: 01/07/2026
https://doi.org/10.67207/mrj.2026.15.08

ХУРААНГУЙ

Дэлхий дахинд тогтвортой байдлын мэдээллийн ач холбогдол нэмэгдэж, хөрөнгө оруулалт болон санхүүгийн шийдвэр гаргалтад өргөн ашиглагдах болсон нь СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх үндсэн нөхцөл болж байна. Энэхүү судалгаа нь Монгол улсад эдгээр стандартуудыг нэвтрүүлэх бэлэн байдлын түвшинг үнэлэх болон НҮБХХ-ийн боловсруулсан 2026–2032 оны нэвтрүүлэх замын зургийг олон улсын туршлагатай харьцуулан үнэлэх зорилготой болно. Судалгаанд СТОУС Сангийн бэлэн байдлын үнэлгээний хэрэгслийг ашиглан экосистем, тайлагнагч байгууллага, дэмжих системийн хүрээнд нийт 18 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн ба НҮБХХ-ийн тайлан, замын зураг, СТОУС ТБ1, ТБ2 стандартууд, хууль эрх зүйн баримт бичгүүдэд баримт бичгийн шинжилгээг хийсэн. Судалгааны үр дүнд нийт шалгуур үзүүлэлтийн 72.2% нь сул болон маш сул түвшинд үнэлэгдэж, өгөгдөл ба дижитал дэд бүтэц, мэргэжлийн үйлчилгээ, техникийн чадавх хамгийн сул байгаа нь харагдаж байна. Мөн замын зураг нь олон улсын туршлагатай нийцсэн, үе шаттай хэрэгжилтийн бодлогын чиглэлтэй боловч үндэсний хүлэмжийн хийн мэдээллийн сан, ТББОУС 5000 стандартын орчуулга, мэргэжлийн хүний нөөцийн тогтолцоонд чиглэсэн нарийвчласан төлөвлөгөө шаардлагатай байна.

Түлхүүр үгс: СТОУС ТБ1, ТБ2, тогтвортой байдлын тайлагнал, бэлэн байдлын үнэлгээ, замын зураг

ОРШИЛ

Дэлхий дахинд тогтвортой байдалтай холбоотой мэдээлэл нь хөрөнгө оруулалт, санхүүгийн шийдвэр гаргалтад чухал болж, ач холбогдол нь нэмэгдсээр байна. Үүнтэй холбоотойгоор СТОУС Сан 2021 онд СОР 26 бага хурлын үеэр Тогтвортой байдлын олон улсын стандартын зөвлөл (ТБОУСЗ)-ийг үүсгэн байгуулж, 2023 оны 6 дугаар сард СТОУС ТБ1 “Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийн тодруулгын ерөнхий шаардлага” болон СТОУС ТБ2 “Уур амьсгалтай холбоотой тодруулга” стандартуудыг батлан гаргасан (IFRS Foundation, 2023). Эдгээр стандартууд нь 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

СТОУС ТБ1 нь тогтвортой байдалтай холбоотой эрсдэл, боломжууд аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, санхүүжилтийн өртөг, урт хугацааны үнэ цэнд хэрхэн нөлөөлж болох талаар хөрөнгө оруулагчдад мэдээлэх ерөнхий шаардлагыг тодорхойлдог. Харин СТОУС ТБ2 нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжууд нь байгууллагын стратеги, бизнес загвар, санхүүгийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж буйг засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, хэмжүүр ба зорилтот үзүүлэлт гэсэн дөрвөн хүрээнд тайлагнахыг шаарддаг.

Монгол улсын эдийн засгийн тулгуур салбарууд болох уул уурхай, мал аж ахуй, санхүүгийн салбарууд нь уур амьсгалын өөрчлөлтийн биет болон шилжилтийн эрсдэлд өндөр өртөмтгий бөгөөд олон улсын хөрөнгө оруулагчид, санхүүжүүлэгчид тогтвортой байдлын тайлагналын шаардаж байна. Энэ нь Монголын компаниудын олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалт татах боломжтой шууд холбоотой тул СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг үндэсний хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлэх, байгууллагуудын мэдлэг, чадавхыг бэхжүүлэх, хэрэгжилтийн бодлогын орчныг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна.

2026 оны 1 дүгээр сард НҮБХХ-өөс Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээний тайланг, мөн оны 4 дүгээр сард үндэсний хэмжээний Замын зургийг олон нийтэд танилцуулсан байна.

Судалгааны зорилго нь Монгол Улсад СТОУС ТБ1, ТБ2-ыг нэвтрүүлэх бэлэн байдлын одоогийн түвшин болон 2026–2032 оныг хамарсан замын зургийг олон улсын туршлагатай харьцуулан үнэлэх, замын зургийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж боловсруулахад оршино.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Судалгаануудын үр дүнгээр байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын мэдээлэл нь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад материаллаг нөлөө үзүүлдэг бөгөөд тогтвортой байдлын эрсдэлийг ил тод тайлагнадаг компаниудын капиталын өртөг буурч, зах зээлийн үнэлгээ нэмэгдэх хандлагатай болохыг тогтоосон байна (Friede, Busch & Bassen, 2015; Bolton & Kacperczyk, 2021). Олон улсын туршлагаас үзэхэд СТОУС ТБ1, ТБ2-ыг амжилттай хэрэгжүүлэхэд зөвхөн компанийн дотоод чадавх бус, экосистемийн орчин болон дэмжих системийн бэлэн байдал чухал үүрэгтэй байна. Судалгаагаар улс орнуудын зохицуулалтын орчин нь тайлагналын бэлэн байдалд хамгийн хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл болохыг тогтоосон. Тухайлбал, Бангладешийн 45 хувьцаат компанид хийсэн судалгаагаар зохицуулагч байгууллагын шаардлага, хууль эрх зүйн орчин нь засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага зэрэг хүчин зүйлсээс илүүтэйгээр

бэлэн байдалд нөлөөлж байжээ (Tonni, 2026). Baboukardos нар (2022) дэлхийн хамгийн өндөр хүлэмжийн хийн ялгаруулалттай химийн болон барилгын материалын салбарын 100 компанид хийсэн судалгаагаар ил тод байдлын түвшин химийн салбарт 43%, барилгын материалын салбарт 39% байгааг тогтоожээ. Засаглалын үзүүлэлт хамгийн өндөр буюу 59–60% байсан бол стратеги 34–38%, эрсдэлийн удирдлага 33–37%-ийн түвшинд байв. Харин СТОУС ТБ2-т шинээр тусгагдсан шаардлагуудын мөрдөлт ердөө 23–27% байсан нь компаниуд шинэ төрлийн мэдээллийг тайлагнахад хүндрэлтэй байгааг илтгэж байна.

Гана улсын 241 олон нийтийн ашиг сонирхлын байгууллагад хийсэн судалгаагаар тогтвортой байдлын тайлагналын бэлэн байдлын индекс дунджаар 46.6% гарсан бөгөөд засаглал 48.25%, стратеги 49.25%, эрсдэлийн удирдлага 46.50%, хэмжүүр ба зорилт 41.00%-ийн түвшинд үнэлэгджээ. Судалгаанд оролцсон байгууллагуудын ердөө 18.7% нь тогтвортой байдлыг хариуцсан удирдлагатай, 15.8% нь тогтвортой байдлын тайлан гаргадаг, 19.9% нь уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөтэй байсан нь байгууллагуудын бодит хэрэгжилтийн түвшин сул байгааг харуулсан байна (Fianko нар, 2025).

Дэмжих системийн хүрээнд баталгаажуулалт, сургалт, өгөгдлийн дэд бүтэц сул хөгжсөн нь нийтлэг асуудал болж байна. Baboukardos нар (2022)-ын судалгаагаар шинжилгээнд хамрагдсан компаниудын ердөө 55% нь уур амьсгалын тодруулгын баталгаажуулалт хийлгэсэн бөгөөд зөвхөн 15 компани тоон болон чанарын мэдээллээ хамтад нь баталгаажуулсан байна. Гана улсад хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэсэн байгууллагын хувь 14.1% байсан бөгөөд 87.5% нь СТОУС ТБ1, ТБ2-ын талаар сургалт шаардлагатай гэж үзэж, 89.9% нь эрсдэлийн удирдлагын чадавхаа бэхжүүлэх хэрэгцээтэй байгаагаа илэрхийлсэн нь тогтвортой байдлын тайлагналын хэрэгжилтэд хүний нөөц, сургалтын асуудал гол сорилт болж байгааг харуулж байна.

Нэвтрүүлэлтийн зургаан загвар

СТОУС Сангаас 2025–2026 онд танилцуулсан 17 улсын замын зургийг харьцуулсан шинжилгээгээр СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх зургаан загвар тодорхойлогдсон ба эдгээрийг Хүснэгт 1-д нэгтгэн харуулав. Загвар сонголт нь тухайн улсын эрх зүйн орчин, институцийн чадавх, зах зээлийн бүтэц болон хөгжлийн түвшнээс хамаардаг байна.

Хүснэгт 1. *СТОУС ТБ1, ТБ2 нэвтрүүлэлтийн загвар*

Загвар	Шинж чанар	Жишиг улсууд
Өөрчлөлтгүй шууд	Дотоодын эрх зүйн актаар иш татан, СТОУС ТБ1, ТБ2-ыг шууд мөрдүүлнэ.	Мексик, Пакистан, Танзани, Замби, Гана
Үндэсний стандарт	ТБОУСЗ-ийн стандартад үндэслэн дотоод хууль эрх зүйн хүчинтэй үндэсний стандарт боловсруулна.	Бразил (CBPS), Шри Ланка (SLFRS), Хонг Конг (HKFRS)
Олон талт зохицуулагч	Олон тусдаа зохицуулагч нэгдсэн стандарт тогтоогчоор уялдана.	Бразил, Хонг Конг
Шууд хэрэглээ	ТБОУСЗ-өөс гаргасан стандартыг шууд нийцлийн мэдэгдэлтэй мөрдүүлнэ.	Чили

Уур амьгалын тодруулгаас эхлэх	СТОУС ТБ2-ыг нэн тэргүүнд хэрэгжүүлж, ТБ1-ийг хойшлуулах.	Австрали, Иордан, Бангладеш, Малайз
Үе шаттай	Компаниудын хэмжээ, чадавхаас хамаарсан шатлал; хялбаршуулсан тодруулга.	Руанда, Тайвань, Турк

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд СТОУС Сан-гаас 2026 онд боловсруулсан “Улсын бэлэн байдлын үнэлгээний хэрэгсэл” (Jurisdictional Readiness Assessment Tool)-ийг үндсэн үнэлгээний хүрээ болгон ашиглаж, экосистемийн бэлэн байдал, тайлан бэлтгэгч байгууллагын бэлэн байдал, дэмжих системийн бэлэн байдал гэсэн гурван үндсэн чиглэлээр үнэлгээ хийсэн. Мөн баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглан НҮБХХ-өөс боловсруулсан “Монгол улсад Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээний тайлан”, “Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх замын зураг 2026–2032”, СТОУС Сан-гийн албан ёсны мэдээлэл, зөвлөмж, СТОУС ТБ1 болон СТОУС ТБ2 стандартууд, түүнчлэн Монгол улсын холбогдох хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийн агуулгад дүн шинжилгээ хийсэн. Үүний хүрээнд дээрх эх сурвалжуудын уялдаа холбоо, стандартын шаардлагатай нийцэж буй байдал, хэрэгжилтийн орчин, институцийн болон техникийн чадавх, замын зурагт тусгагдсан зорилт, үе шат, хэрэгжилтийн механизмын бодитой байдлыг олон улсын туршлагатай харьцуулан үнэлсэн болно.

МОНГОЛ УЛСЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

СТОУС Сангийн бэлэн байдлын үнэлгээний хэрэгсэлд тулгуурлан Монгол улсын бэлэн байдлыг гурван түвшин буюу экосистемийн бэлэн байдал, тайлагнагч байгууллагын бэлэн байдал, дэмжих системийн бэлэн байдал болгон хувааж үнэлсэн ба эдгээр түвшинг нийт зургаан чиглэлд (A-F) ангилан 18 шалгуур үзүүлэлтээр шинжилгээ хийсэн болно.

Экосистемийн бэлэн байдал

Чиглэл A: Зохицуулалтын бүтэц ба институцийн суурь

Монгол улсад СТОУС-ын санхүүгийн тайлагналын стандартыг 1993 оноос хуульчлан хэрэгжүүлж ирсэн нь СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх институцийн суурь болж байна. НҮБХХ-ийн бэлэн байдлын судалгаагаар байгууллагуудын 84.7% нь СТОУС хэрэглэж байгаа нь олон улсын стандартад суурилсан тайлагналын орчин бүрэлдсэнийг харуулж байна. Гэвч тогтвортой байдлын тайлагналтай холбоотой хууль эрх зүйн орчин хангалтгүй хэвээр байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Мөн зохицуулагч байгууллагуудын СТОУС ТБ1, ТБ2 стандартын талаарх мэдлэг, техникийн чадавх сул, дижитал дэд бүтэц хангалтгүй, мэргэшсэн хүний нөөцийн хомсдолтой байгаа нь хэрэгжилтийн гол сорилт болж байна.

Чиглэл B: Мэргэжлийн үйлчилгээ

Тогтвортой байдлын тайлагналтай холбоотой мэргэжлийн үйлчилгээний зах зээл Монгол улсад хангалтгүй түвшинд байна. Хүлэмжийн хийн тооцоолол, сценари

шинжилгээ, баталгаажуулалт зэрэг чиглэлээр мэргэшсэн нягтлан бодогч, зөвлөх, баталгаажуулагчдын тоо цөөн байгаа нь СТОУС ТБ1, ТБ2 стандартуудын хэрэгжилтэд хүндрэл учруулж байна. Байгууллагуудын зөвхөн 16.4% нь хамрах хүрээ 1-ийн, 13.2% нь хамрах хүрээ 2-ын, 10.1% нь хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжиж байгаа бол сценари шинжилгээ хийдэг байгууллага ердөө 4.8% байна. Мөн тогтвортой байдлын баталгаажуулалтын үйлчилгээ нь заавал мөрдөх шаардлагагүй хэвээр байгаа бөгөөд байгууллагуудын 14.8% нь дотоод, 29.6% нь гадаад баталгаажуулалт хийдэг эсвэл төлөвлөж байгаа гэж хариулсан байна. Түүнчлэн ТББОУС 5000 стандартын хэрэгжилт бүрдээгүй, стандартын орчуулга болон мэргэжлийн сургалтын тогтолцоо хангалтгүй байгаа нь мэргэжлийн үйлчилгээний экосистем сул байгааг харуулж байна.

Чиглэл C: Мэдээлэл, өгөгдөл ба дижитал дэд бүтэц

Монгол улсад тогтвортой байдлын тайлагналд шаардлагатай өгөгдөл, мэдээллийн систем, дижитал дэд бүтэц хангалтгүй түвшинд байна. Үндэсний хэмжээний хүлэмжийн хийн нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна. Байгууллагуудын ердөө 2.6% нь тогтвортой байдлын тайлагналын зориулалтын программ ашиглаж байгаа нь аналитик хэрэгсэл, өгөгдлийн боловсруулалтын чадавх сул байгааг харуулж байна. Сценари шинжилгээ, санхүүгийн нөлөөллийн тооцоолол хийх дижитал хэрэгсэл хангалтгүй, И-Баланс системийн суурь бүрдсэн боловч СТОУС ТБ1, ТБ2-д нийцсэн дижитал тайлагналын орчин хараахан хөгжөөгүй байна.

Тайлагнагч байгууллагын бэлэн байдал

Чиглэл D: Төлөвшил, ур чадвар болон мэргэжлийн чадавх

Тайлан бэлтгэгч байгууллагуудын тогтвортой байдлын эрсдэл, боломжийг тодорхойлох, үнэлэх, удирдах чадавх ерөнхийдөө сул түвшинд байна. НҮБХХ-ийн судалгаагаар байгууллагуудын ердөө 12.2% нь уур амьсгалын эрсдэлийг үнэлдэг, 9.0% нь уур амьсгалын эрсдэлийг байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэсэн, харин сценари шинжилгээ хийдэг байгууллага дөнгөж 4.8% байна. Түүнчлэн байгууллагуудын зөвхөн 24.3% нь тогтвортой байдлын асуудлыг ТУЗ-ийн түвшинд тогтмол хэлэлцдэг, 19.6% нь тусгай хяналтын тогтолцоотой байгаа нь тогтвортой байдлын засаглалын бүтэц сул хөгжсөнийг харуулж байна.

Мэргэжлийн болон техникийн чадавхын хувьд байгууллагуудын ердөө 22.8% нь тогтвортой байдлын асуудал хариуцсан тусгай мэргэжилтэнтэй бөгөөд 72% нь энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй байна. Өгөгдөл боловсруулах, тайлагнах системийн хувьд ердөө 2.6% нь БОНЗ тайлагналын зориулалтын программ ашиглаж, ихэнх байгууллага Excel зэрэг гар ажиллагаанд тулгуурласан хэрэгсэл ашиглаж байгаа нь дижитал чадавх сул байгааг илтгэнэ. Мөн өгөгдлийн дотоод хяналтын тогтолцоотой байгууллага 16.4%, тогтвортой байдлын тайлагналын баталсан дүрэм, журамтай байгууллага 15.9%, дотоод баталгаажуулалт хийдэг байгууллага 14.8% байгаа нь тайлагналын засаглалын тогтолцоо бүрдээгүйг харуулж байна.

Тайлагналын практикийн хувьд байгууллагуудын 21.7% нь ямар нэгэн хэлбэрээр тогтвортой байдлын тайлан гаргадаг боловч эдгээр нь ихэвчлэн санхүүгийн тайлангаас тусдаа, хөрөнгө оруулагчдын санхүүгийн материаллаг мэдээллийн хэрэгцээнд чиглээгүй хэвээр байна. Тайлагналын хүрээнд ТОУС (GRI)-ыг 9.5%, ТОУНББ (SASB)-ыг 5.3%, TCFD-ийг ердөө 0.5% нь ашиглаж байгаа бөгөөд СТОУС ТБ1, ТБ2 стандартуудад бүрэн нийцсэн гэж мэдэгдсэн байгууллага одоогоор байхгүй байна.

Тайлагналын төлөвшил нь байгууллагын хэмжээ, салбараас ихээхэн хамаарч ялгаатай байна. МХБ-ийн I ангиллын компаниуд болон томоохон банкуудын бэлэн байдлын түвшин харьцангуй өндөр байгаа бол судалгаанд оролцсон 500-аас цөөн ажилтантай байгууллагуудын дийлэнх нь 20%-иас доогуур бэлэн байдлыг үнэлжээ. Салбарын хувьд уул уурхай болон банк, санхүүгийн байгууллагууд илүү ахицтай байгаа бол хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбаруудын чадавх хамгийн сул байна.

Чиглэл E: Тайлагналын шаардлагын талаарх мэдлэг ба тайлагналын практик

СТОУС ТБ1, ТБ2 стандартуудын талаарх мэдлэг Монгол улсад нэршлийн түвшинд тодорхой хэмжээнд бүрдсэн боловч гүнзгий ойлголт, практик хэрэглээ сул хэвээр байна. НҮБХХ-ийн судалгаагаар байгууллагуудын 63.5% нь СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэрээр нь мэддэг гэж хариулсан ч 69.8% нь ойлголтоо 40%-иас доогуур түвшинд үнэлжээ. Харин мэдлэгээ “өндөр” түвшинд үнэлсэн байгууллага ердөө 4.2%, “дунджаас дээгүүр” түвшинд үнэлсэн нь 7.4% байсан байна. Мөн байгууллагуудын 72% нь албан ёсны сургалтад хамрагдаагүй байгаа нь мэдлэгийн суурь хангалтгүй байгааг илтгэнэ.

Одоогийн тайлагналын практик нь үндсэндээ дотоодын зохицуулалт, олон улсын хөрөнгө оруулагчдын шаардлага болон сайн дурын санаачилгад тулгуурлан хөгжиж байна. МХБ 2023 оноос I ангиллын компаниудад БОНЗ тайлан гаргахыг заавал болгосон нь гол хөдөлгөгч хүчин зүйл болсон бол олон улсын хөрөнгө оруулагчидтай уул уурхайн компаниуд, ногоон санхүүжилт авсан банкууд тогтвортой байдлын тайлагналыг илүү идэвхтэй хэрэгжүүлж байна.

Дэмжих системийн бэлэн байдал

Чиглэл F: Дэмжих системийн тогтолцоо

Монгол улсад СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх дэмжих системийн суурь орчин тодорхой хэмжээнд бүрдэж эхэлсэн боловч институцичлэгдсэн, тогтвортой тогтолцоо хараахан бүрдээгүй байна. НҮБХХ, АХБ, ОУСК, СТОУС Сан зэрэг олон улсын байгууллагууд Сангийн яам, СЗХ, Монголбанк, МХБ, ММНБИ-тэй хамтран сургалт, зөвлөмж, туршилтын тайлагнал, бодлогын дэмжлэг үзүүлж байгаа боловч эдгээр нь ихэвчлэн нэг удаагийн, төслийн шинжтэй байна.

Судалгаагаар байгууллагуудын 72% нь тогтвортой байдлын тайлагналын сургалтад хамрагдаагүй, 77.2% нь сургалт, 65.6% нь загвар маягт, 62.4% нь техникийн заавар шаардлагатай гэж хариулсан нь чадавх бэхжүүлэх хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Мөн ММНБИ-ийн мэргэжлийн боловсролын тогтолцоонд СТОУС ТБ1, ТБ2-ын тусгай модуль ороогүй, ТББОУС 5000 стандарт монгол хэлээр орчуулагдаагүй байгаа нь мэргэжлийн үйлчилгээний дэмжлэг сул байгааг илтгэж байна.

Мэдээлэл, дата дэд бүтцийн хувьд үндэсний хэмжээний хүлэмжийн хийн ялгарлын коэффициентийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, тогтвортой байдлын тайлагналын программ хангамжийн хэрэглээ маш бага, И-Баланс системийг СТОУС ТБ-д нийцүүлэн өргөтгөх ажил төлөвлөлтийн шатанд байна.

Нэгдсэн үнэлгээ

Монгол улс СТОУС ТБ1, ТБ2-ыг нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээг нь Хүснэгт 2-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 2. *Нэгдсэн бэлэн байдлын үнэлгээ*

Код	Үзүүлэлт	Гол дүгнэлт	Үнэлгээ
I. ЭКОСИСТЕМИЙН БЭЛЭН БАЙДАЛ			
Чиглэл A: Зохицуулалтын бүтэц ба институцийн суурь			
A(a)	СТОУС НББ стандартын хэрэглээ	Байгууллагуудын 84.7% нь СТОУС НББ стандартыг хэрэглэж байна.	**Сайн**
A(b)	Хууль эрх зүй, зохицуулалт	Заавал мөрдүүлэх хууль эрх зүйн зохицуулалт байхгүй; НББ, ҮЦЗЗ-ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт шаардлагатай.	**Сул**
A(c)	Зохицуулагчийн техник чадавх	СТОУС ТБ1, ТБ2-ын мэдлэг сул; дижитал дэд бүтэц хангалтгүй; чадавхжуулах сургалт шаардлагатай.	**Сул**
Чиглэл B: Мэргэжлийн үйлчилгээ			
B(a)	Тайлагналын мэргэжилтнүүд	ХХЯ нягтлан бодогч, сценари шинжээч, баталгаажуулагч — гурван чиглэлд хүний нөөцийн хомсдолтой.	**Сул**
B(b)	Зөвлөх үйлчилгээ	СТОУС ТБ1, ТБ2-ын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага цөөн.	**Сул**
B(c)	Баталгаажуулалтын үйлчилгээ	Заавал шаардлага байхгүй; ТББОУС 5000 мэргэшил бүрдээгүй, стандарт орчуулагдаагүй.	**Маш сул**
B(d)	Хууль зүйн зөвлөх үйлчилгээ	Тогтвортой байдлын эрх зүйд мэргэшсэн хуулийн зөвлөх бараг байхгүй; хариуцлагын хүрээ тодорхой бус.	**Сул**
Чиглэл C: Мэдээлэл, дата ба дижитал дэд бүтэц			
C(a)	Гадаад өгөгдлийн хүртээмж	16.4% нь Хамрах хүрээ 1-ийг, 10.1% нь Хамрах хүрээ 3-ыг хянадаг; үндэсний ХХЯ-ын коэффициентийн сан байхгүй.	**Маш сул**
C(b)	Аналитик хэрэгсэл	2.6% нь тогтвортой байдлын программ ашигладаг; сценари шинжилгээ, санхүүгийн нөлөөллийн хэрэгсэл хангалтгүй.	**Маш сул**
C(c)	Дижитал тайлагнал	И-Баланс суурь бий; СТОУС ТБ-д өргөтгөл хийгдээгүй.	**Хөгжиж буй**
II. ТАЙЛАГНАГЧ БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ			
Чиглэл D: Төлөвшил, ур чадвар ба мэргэжлийн чадавх			
D(a)	Эрсдэлийн удирдлага	12.2% нь уур амьсгалын эрсдэлийг үнэлдэг; 9.0% нь нэгдсэн эрсдэлийн удирдлагад нэгтгэсэн; 4.8% нь сценари шинжилгээ хийдэг.	**Сул**
D(b)	Тайлагналын төлөвшил	21.7% нь тогтвортой байдлын тайлан гаргадаг; 72% нь сургалтад хамрагдаагүй; дотоод хяналт сул.	**Хөгжиж буй**
Чиглэл E: Тайлагналын мэдлэг ба практик			
E(a)	СТОУС ТБ1, ТБ2-той танилцсан байдал	63.5% нэрээр мэддэг; 69.8% нь ойлголтоо 40%-иас доогуур гэж үнэлсэн; 28% сургалтад хамрагдсан.	**Хөгжиж буй**
E(b)	Одоогийн практик	СТОУС ТБ1, ТБ2-ын шаардлагад бүрэн нийцсэн байгууллага байхгүй.	**Сул**
III. ДЭМЖИХ СИСТЕМИЙН БЭЛЭН БАЙДАЛ			
Чиглэл F: Дэмжлэгийн тогтолцоо			
F(a)	Зохицуулагчдын дэмжлэг	НҮБХХ, АХБ, СТОУС Сангийн түншлэл бий; оролцоо нэг удаагийн шинжтэй, институцичлагдаагүй.	**Сул**
F(b)	Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн дэмжлэг	ММНБИ олон улсын нөөцөд хандах боломжтой ч бодит ашиглалт бага; мэргэшлийн модуль бүрдээгүй.	**Сул**

F(c)	Мэдээлэл, дата дэд бүтцийн дэмжлэг	Үндэсний ялгарлын коэффициентийн сан байгуулах нэн тэргүүний зорилт; санхүүжилт баталгаажаагүй.	**Маш сул**
F(d)	Тайлагнагч байгууллагуудад дэмжлэг	Сургалтын суурь бий; зөвлөгөө өгөх нэгж байгуулах, алсын зайн сургалтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай.	**Хөгжиж буй**

Сайн	**Хөгжиж буй**	**Сул**	**Маш сул**
1	**4**	**9**	**4**

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Үр дүнг нэгтгэн харвал нийт 18 шалгуур үзүүлэлтийн ердөө 1 буюу 5.6% нь “Сайн” түвшинд, 4 буюу 22.2% нь “Хөгжиж буй” түвшинд үнэлэгдсэн байна. Харин үлдсэн 13 шалгуур үзүүлэлт буюу 72.2% нь “Сул” болон “Маш сул” түвшинд үнэлэгдсэн нь Монгол Улсад СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх институцийн орчин, мэргэжлийн үйлчилгээ, өгөгдөл ба дижитал дэд бүтэц, тайлагнагч байгууллагуудын чадавх, дэмжих системийн бэлэн байдал хангалтгүй байгааг харуулж байна.

НҮБХХ-ИЙН ЗАМЫН ЗУРГИЙН ШИНЖИЛГЭЭ

НҮБХХ-ийн “Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх замын зураг 2026–2032”-т тусгасан Монгол улсад тогтвортой байдлын стандартуудыг нэвтрүүлэх дөрвөн үе шат бүхий тогтолцоог Хүснэгт 3-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 3. *НҮБХХ-ийн замын зургийн дөрвөн үе шатны нэгтгэл*

Үе шат	**Хугацаа**	**Гол арга хэмжээ**	**Хамрах хүрээ**
1. Суурь бэлтгэл	2026–2027	Хууль эрх зүйн шинэчлэл; Үндэсний зохицуулах хороо байгуулах; загвар боловсруулах; сайн дурын тайлагнал эхлүүлэх	~50 компани (МХБ-ийн I ангилал)
2. Турших, өргөжүүлэх	2028–2029	СТОУС ТБ2-ыг I ангилалд албан журмаар нэвтрүүлэх; И-Баланс өргөтгөл; ТББОУС 5000 нэвтрүүлэх	~50 компани, банкууд, томоохон ТӨК
3. Хамрах хүрээг өргөжүүлэх	2029–2030	СТОУС ТБ1-ийг нэмж нэвтрүүлэх; хязгаарлагдмал баталгаажуулалт; давхар материаллаг байдал турших	~450 ОНАСБ (>50 тэрбум төгрөг)
4. Тогтолцоог бэхжүүлэх	2031–2032	Томоохон ОНАСБ, II ангилал хамруулах; иж бүрэн баталгаажуулалтын бэлтгэл	Нийт 500+ байгууллага

Эх сурвалж: НҮБХХ (2026)

Баримт бичгийн шинжилгээний үр дүнгээр замын зурагт хэд хэдэн давуу тал тодорхойлогдож байна. Үүнд:

- Замын зураг нь олон улсын шилдэг туршлагатай нийцсэн үе шаттай нэвтрүүлэх хандлагыг баримталсан байна. Тухайлбал, СТОУС ТБ2 буюу уур амьсгалтай холбоотой тодруулгаар эхэлж, дараагийн шатанд СТОУС ТБ1-ийг өргөжүүлэн хэрэгжүүлэх стратеги нь Австрали, Иордан, Бангладеш, Малайз зэрэг улсын загвартай үзэл баримтлалын хувьд нийцэж байна. Мөн энэхүү нэвтрүүлэлтийн загвар нь Монгол улсын бэлэн байдлын үнэлгээнд уур амьсгалын эрсдэл, өгөгдөл, сценари шинжилгээний чиглэл хамгийн сул гарсан үр дүнтэй уялдаж байна.

- Сайн дурын хэрэгжилтээс албан журмын тайлагнал руу үе шаттай шилжих бодлогын хандлага нь Малайз, Гана, Шри Ланка зэрэг улсын туршлагатай нийцэж байна. Замын зурагт 2026–2027 онд МХБ-ийн I ангиллын ойролцоогоор 50 компанид сайн дурын тайлагналыг дэмжиж, 2028 оны санхүүгийн жилээс эхлэн албан журмаар мөрдүүлэхээр төлөвлөсөн нь аж ахуйн нэгжүүдийн дасан зохицох хугацааг тооцсон бодлогын давуу тал болж байна.
- Шилжилтийн үеийн хөнгөлөлтийн зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгарлын тайлагналыг нэг жилээр, сценари шинжилгээний тоон үнэлгээг гурван жил хүртэл хугацаагаар хойшлуулах, мөрдөх эсвэл тайлбарлах зарчмыг хэрэглэх зэрэг нийт зургаан төрлийн шилжилтийн хөнгөлөлтийг замын зургийн хавсралтад тусгасан нь байгууллагуудын техникийн болон өгөгдлийн бэлэн байдлыг харгалзан үзсэн уян хатан бодлого болсон байна.
- Замын зурагт урт хугацаанд давхар материаллаг байдлын хандлага руу шилжих чиглэлийг тусгасан нь стратегийн чухал ач холбогдолтой байна. Энэ нь Монголын экспортлогч аж ахуйн нэгжүүдийг Европын Холбоо-ны CSRD болон нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын шаардлагуудтай уялдуулах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын орчинд өрсөлдөх чадварыг хадгалах нөхцөл болно.
- Сангийн яамны манлайлал дор Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын хөрөнгийн бирж, ММНБИ, ТоС холбоо, МҮХАҮТ зэрэг төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудыг хамруулсан үндэсний зохицуулах хорооны бүтэц төлөвлөсөн нь олон талт оролцоонд суурилсан зохицуулалтын загварыг бүрдүүлэх давуу талтай байна.

Замын зургийн агуулга нь олон улсын туршлага, бэлэн байдлын үнэлгээний үр дүнтэй уялдсан чиглэлийг тодорхойлсон боловч хэрэгжилтийн түвшинд хэд хэдэн чухал асуудлыг илүү нарийвчлан төлөвлөх шаардлагатай байна. Үүнд:

- Хүлэмжийн хийн ялгарлын үндэсний мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудал тодорхойгүй хэвээр байна. Замын зурагт үндэсний ХХЯ-ын платформ байгуулах зорилт тусгагдсан боловч санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжилтийн үе шат, оролцогч байгууллагуудын үүрэг хариуцлагын хуваарилалт хангалттай нарийвчлагдаагүй байна.
- Баталгаажуулалтын тогтолцооны суурь болох ТББОУС 5000 стандартын монгол орчуулга, хэрэгжилтийн бэлтгэл хангалтгүй байна. Тус стандарт 2026 оны 12 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр хүлээгдэж байгаа боловч одоогоор монгол хэлээр орчуулагдаагүй бөгөөд замын зурагт зөвхөн хоёрдугаар үе шатанд орчуулах ерөнхий чиглэл тусгасан байна. ММНБИ-ийн орчуулга, хянан баталгаажуулалт, нийтлэл, сургалтын нарийвчилсан төлөвлөгөө тодорхойгүй байгаа нь баталгаажуулалтын үйлчилгээний бэлэн байдалд сөргөөр нөлөөлөхөөр байна.
- Орон нутгийн хүртээмж болон жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын дэмжлэг хангалтгүй төлөвлөгдсөн байна. Олон улсын аудитын фирмүүд, зөвлөх үйлчилгээ, мэргэжлийн сургалтын байгууллагууд Улаанбаатар хотод төвлөрсөн

байдаг бөгөөд 21 аймагт тогтвортой байдлын тайлагналын мэргэшсэн боловсон хүчний хүртээмж маш бага байна. Гэвч алсын зайн сургалт, цахим платформ, орон нутгийн зөвлөгөө өгөх лавлах нэгж байгуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн хугацаа, төсөв, санхүүжилтийн механизм замын зурагт хангалттай тодорхойлогдоогүй байна.

- Замын зурагт тусгагдсан тоон зорилтуудын бодитоор хэрэгжих боломжтой эсэхийг дахин үнэлэх шаардлагатай байна. Тухайлбал, 2032 он гэхэд нийцлийн түвшин 95 хувь, баталгаажуулалтын түвшин 80 хувьд хүрэх зорилт дэвшүүлсэн боловч өнөөгийн нөхцөлд байгууллагуудын ердөө 4.2% нь мэдлэгээ өндөр түвшинд үнэлж, 21.7% нь тогтвортой байдлын тайлан гаргаж байгаа үзүүлэлттэй харьцуулахад энэхүү өсөлтийн хурд бодит хэрэгжих боломжтой эсэх нь тодорхой бус байна.
- Дээд боловсролын тогтолцоотой уялдуулах асуудал сул тусгагдсан байна. Одоогийн байдлаар тогтвортой байдлын тайлагналын агуулгыг сургалтын төлөвлөгөөндөө системтэй тусгасан цөөн жишээний нэг нь Мандах их сургууль байгаа бөгөөд МУИС, СЭЗИС зэрэг тэргүүлэх их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр, мэргэжлийн сертификат, судалгааны төв, багш бэлтгэх тогтолцооны талаар нарийвчилсан хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын СТОУС ТБ1, ТБ2 стандартуудыг нэвтрүүлэх бэлэн байдал сул түвшинд байгааг судалгааны үр дүн харуулж байна. Нийт 18 шалгуур үзүүлэлтийн 72.2% нь “сул” болон “маш сул” үнэлгээтэй гарсан нь хууль эрх зүйн орчин, мэргэжлийн үйлчилгээ, өгөгдөл ба дижитал дэд бүтэц, тайлагнагч байгууллагын техникийн чадавх хангалтгүй байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч байгууллагуудын 84.7% нь СТОУС нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэглэж байгаа нь институцийн суурь орчин байгааг харуулж байна. Энэ нь Монгол улсад тогтвортой байдлын тайлагналыг бүрэн шинээр бий болгохоос илүүтэйгээр одоо байгаа санхүүгийн тайлагналын тогтолцоон дээр өргөтгөн хөгжүүлэх боломжтойг илэрхийлж байна.

НҮБХХ-ийн боловсруулсан “Замын зураг 2026–2032” нь олон улсын туршлагатай нийцсэн баримт бичиг болсон байна. СТОУС ТБ2 буюу уур амьсгалтай холбоотой тодруулгаар эхэлж, дараагийн шатанд СТОУС ТБ1-ийг өргөжүүлэх “climate-first” арга барил нь Австрали, Малайз, Бангладеш зэрэг улсын туршлагатай нийцэж байна. Мөн шилжилтийн үеийн хөнгөлөлтийн механизм, мөрдөх эсвэл тайлбарлах зарчим, давхар материаллаг байдал руу үе шаттай шилжих бодлого, олон талт зохицуулагчийн бүтэц зэрэг нь олон улсын туршлагад тулгуурласан оновчтой шийдлүүд болж байна.

Гэвч замын зургийн амжилттай хэрэгжилт нь хэд хэдэн институцийн болон техникийн суурь асуудлыг хугацаанд нь шийдвэрлэхээс шууд хамаарахаар байна. Үүнд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг 2026–2027 онд батлуулах, үндэсний хэмжээний хүлэмжийн хийн коэффициентийн нэгдсэн мэдээллийн санг 2028 онд ашиглалтад оруулах, мөн ТББОУС 5000 стандартын монгол орчуулга болон баталгаажуулалтын мэргэшлийн тогтолцоог 2027–2028 онд бүрдүүлэх асуудлууд багтаж байна. Эдгээр суурь нөхцөлүүд хугацаандаа бүрдээгүй тохиолдолд замын зурагт тусгагдсан үе шаттай нэвтрүүлэлтийн зорилтууд хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Bolton, P., & Kacperczyk, M. (2021). Do investors care about carbon risk? Journal of Financial Economics, 142(2), 517–549.

Fianko, A., Mensah, A., Tackie, G., & Asare, N. (2025). Sustainability reporting readiness: Evidence from public interest entities in Ghana. ICAG & WACAR.

Friede, G., Busch, T., & Bassen, A. (2015). ESG and financial performance: Aggregated evidence from more than 2000 empirical studies. Journal of Sustainable Finance & Investment, 5(4), 210–233.

IAASB (2024). International Standard on Sustainability Assurance (ISSA) 5000: General Requirements for Sustainability Assurance Engagements. New York.

IFRS Foundation (2023). IFRS S1: General Requirements for Disclosure of Sustainability-related Financial Information. London.

IFRS Foundation (2023). IFRS S2: Climate-related Disclosures. London.

IFRS Foundation (2026). Use of IFRS Sustainability Disclosure Standards by Jurisdiction: Jurisdictional Profiles and Snapshots.

Modjaningrum, D., & Hermawan, A. (2025). Assessing readiness for adoption of IFRS S1 and IFRS S2: A case study of Indonesia's Central Counterparty. International Journal of Economics, Business and Accounting Research, 9(1), 1081–1101.

Tonni, S. A. (2026). IFRS S2 climate-related disclosure adoption readiness: Empirical evidence from Bangladesh. Journal of Sustainable Finance Research.

Монгол Улсын Их Хурал. (1993, 2015 шинэчилсэн найруулга). Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.

ММНБИ (2024). СТОУС ТБ1, ТБ2 стандартуудын монгол орчуулга. Улаанбаатар.

ММНБИ (2026). СТОУС ТБ1, ТБ2 стандартыг нэвтрүүлэх боломжийн судалгааны тайлан. Улаанбаатар.

Монголбанк (2025). Монголын санхүүгийн байгууллагуудад зориулсан уур амьсгалын нөлөөллийн тайлагналын удирдамж. Улаанбаатар.

НҮБХХ (2026). Монгол Улсад Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээний тайлан. Улаанбаатар.

НҮБХХ (2026). Тогтвортой байдлын тодруулгын стандартыг нэвтрүүлэх замын зураг 2026–2032. Улаанбаатар.